МОНГОЛ УЛС
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**
14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020.11.09 № 05/12535
танай 2020.11.04-ны № 9/2232-т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.ИДЭРБАТ ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн дараах нэр бүхий этгээдүүдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянахад:

1. Мягмаржавын Шүрэнцэцэгийг Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг даргаар,
2. Арслангийн Мөнхбайгалийг Норовлин сумын Засаг даргаар,
3. Баатарсүрэнгийн Эрдэнэбаатарыг Өмнөдэлгэр сумын Засаг даргаар,
4. Дашпүрэвийн Мөнх-Одыг Дадал сумын Засаг даргаар,
5. Батсүхийн Амгаланбатыг Баянхутаг сумын Засаг даргаар тус тус томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Д.Мөнх-Од нь амьтан өсгөх үйл ажиллагаа, аялал жуулчлал, мод, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг "Өнөрчийн гол" ХХК-ийн захирлаар бүртгэлтэй байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт, хориглолтыг хэрэгжүүлж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР Л.СҮХ-ОЧИР